

2016 он 08 сар 28 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Батлан даалт гаргах, хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15, 6.2.7.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Таванбогд Констракшн Машинери ХХК-ийн Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (цаашид “ЕСБХБ” гэх)-тай байгуулах 143,000,000,000 (нэг зуун дөчин гурван тэрбум) төгрөг хүртэлх дүн бүхий зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд батлан даалт гаргах, холбогдох батлан даалтын гэрээг ЕСБХБ-тай байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан Таванбогд Констракшн Машинери ХХК-ийн ЕСБХБ-тай байгуулах зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар ЕСБХБ-нд өмнө нь барьцаалуулсан Хавсралт 1-т заасан хөрөнгийг ЕСБХБ эсхүл түүнийг албан ёсоор төлөөлөх, нэрлэн заасан этгээдэд нэмж барьцаалуулах, холбогдох барьцааны гэрээнүүдийг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 болон 2 дахь хэсэгт заасан батлан даалт болон барьцааны гэрээнүүдийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, улмаар тус батлан даалт болон барьцааны гэрээнүүдэд Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаараа эсвэл хамтран хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан), Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарт тус тус олгосугай.
4. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА



Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР